



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Give 2 Asia олон улсын тусламжийн байгууллага, Швейцарь улсын “Анита” сантай байгуулсан гэрээний хүрээнд ашгийн бус байгууллагын санхүүжилтээр Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдсан дунд зэргийн төвөгшлийн ангиллын 48 ортой оюутны үйлчилгээний төвийн зориулалттай, 343,847,065.53 (гурван зуун дөчин гурван сая найман зуун дөчин долоон мянга жаран таван төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг Монгол Улсын Боловсролын их сургуулийн салбар Баян-Өлгий аймаг дахь Багшийн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын боловсролын их сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Алтангоо нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасгай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004739

10-r huraldaan.docx